

**ГАЗРЫН ТОСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР БОЛОН ГАЗРЫН ТОСНЫ
ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ,
ХУВААРИЛАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Төсвийн тухай хууль болон Газрын тосны тухай хуульд заасан газрын тосны нөөц ашигласны төлбөр болон газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Газрын тосны нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлэх

2.1. Газрын тосны нөөц ашигласны төлбөрийг олборлосон буюу худалдахаар ачилт хийсэн, ашигласан тухай бүр бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувиар холбогдох журамд заасан аргачлалаар тооцож ногдуулна.

2.2. Гэрээлэгч нь тухайн сард олборлосон буюу худалдахаар ачуулсан болон ашигласан газрын тосны тоо хэмжээ, үнэ, үнэлгээг үндэслэн нөөц ашигласны төлбөрийг ногдуулсан тайлан, мэдээг дараа сарын 20-ны дотор гарган газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд төлбөрийг тайлан хүргүүлснээс хойш 5 хоногийн дотор тус байгууллагын валютын дансанд, эсхүл түүнтэй тэнцэх төгрөгийг тухайн өдрийн Монгол банкнаас тогтоосон албан ёсны ханшийг баримтлан төгрөгийн дансанд төвлөрүүлнэ.

2.3. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тайлан, мэдээг хянаж, нөөц ашигласны төлбөрийг Монгол Улсын Засгийн газарт ногдох бусад орлогын хамт гэрээлэгч төлбөр төлснөөс хойш ажлын 5 хоногийн дотор Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлнэ.

2.4. Төрийн захиргааны байгууллага нь Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн Нөөц ашигласны төлбөр болон Монгол Улсын Засгийн газарт ногдох бусад орлогын хувь хэмжээний мэдээг бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай тус бүрээр гарган дараа сарын 10-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг тооцох, төлөх

3.1. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан болон эрх бүхий байгууллагаас тогтоосон талбайн хэмжээнд үндэслэн Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, 30.4, 30.5 дахь заалт, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу тусгай зөвшөөрлийн төлбөрийг тооцож, төлбөрийн нэхэмжлэлийг гэрээлэгчид хүргүүлнэ.

3.2. Гэрээлэгч тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэхэмжлэхэд заасан хугацаанд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дансанд төвлөрүүлнэ.

3.3. Газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн өдрийг банкны гүйлгээ хийгдэж дансанд орсон өдрөөр тооцно.

3.4. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын тооцоог хянаж тухай бүр Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлнэ.

3.5. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6-д заасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн харьяалах аймаг, нийслэл, сум, дүүргэд хуваарилах тооцоог хийж, дүнгийн мэдээг дараа сарын 10-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.6. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь болон гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу тодорхой хэсгийг буцаан өгсөн, эсхүл газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр цуцалсан нь өмнө төлсөн тусгай зөвшөөрлийн төлбөрийг бууруулах, буцаан олгох үндэслэл болохгүй.

Дөрөв. Газрын тосны нөөц ашигласны төлбөр, газрын тосны хайгуул, ашиглалтын талбайн тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуваарилах

4.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.11, 23.4.12, 23.6.9, 23.8.13 болон 59 дүгээр зүйлийн 59.1.5-д заасан мөн Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6, 31 дүгээр зүйлийн 31.3-д заасны дагуу тус тус Төрийн сангийн нэгдсэн данснаас хуваарилна.

4.2. Тухайн сард газрын тосны борлуулалтаас Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрсөн газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 30 хоногт багтаан Төрийн сангийн нэгдсэн данснаас тухайн газрын тосны орд байршиж байгаа орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5-д заасны дагуу хуваарилна.

4.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан энэ журмын 2.4, 3.5 -д заасан тооцооны дагуу тухайн аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогын дансанд хуваарилна.

4.4. Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогын дансанд шилжүүлсэн өдрөөс хойш 10 хоногт багтаан сум, дүүргийн төсвийн татварын орлогын дансанд хуваарилна.

Тав. Газрын тосны нөөц ашигласны төлбөр, газрын тосны хайгуул, ашиглалтын талбайн тусгай зөвшөөрлийн төлбөрийг зарцуулах

5.1. Энэхүү журамд заасны дагуу нөөц ашигласны төлбөр болон газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн хөрөнгийг хуулийн дагуу төсвийн орлогод бүртгэн, Монгол Улсын Төсвийн болон Төсвийн

байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу захиран зарцуулна.

5.2. Тухайн газрын тосны орд байршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн ерөнхийлөн захирагч нь хуваарилагдсан тусгай зөвшөөрлийн төлбөрийг орон нутгийн төсвийн санхүүжилтэд зарцуулна.

Зургаа. Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн төлөлт хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих

6.1. Аймаг, нийслэл төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвөөс орон нутгийн төсөвт, орон нутгийн төсвөөс улсын төсөвт хуваарилж байгаа газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөр, түүний зарцуулалт холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хийгдсэн байдалд байнгын хяналт тавьж ажиллана.

6.2. Төсөвт төвлөрүүлсэн газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн зарцуулалтад санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавина.

6.3. Гэрээлэгч хуулийн этгээд нь олборлож, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ болон төсөвт төвлөрүүлэх газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож, төсөвт төвлөрүүлсэн байдалд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллага тус тус хяналт тавьж ажиллана.

Долоо. Хариуцлага хүлээлгэх

7.1. Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөө төлөөгүй хуулийн этгээдэд Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8-д заасны дагуу хариуцлага тооцно. Энэхүү журмын тухай хуульд заасны дагуу газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тооцож төвлөрүүлээгүй, эсхүл зарцуулаагүй бол Зөрчлийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----0----